



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 634

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021, 2022 оны 133, 36, 49, 50 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дундговь аймгийн өмчөөс шилжүүлсэн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нийт 1,110,949,610.00 (нэг тэрбум нэг зуун арван сая есөн зуун дөчин есөн мянга зургаан зуун арван) төгрөгийн балансын үнэ, 31,265,222.00 (гучин нэгэн сая хоёр зуун жаран таван мянга хоёр зуун хорин хоёр) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч хавсралтад заасны дагуу төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн "Дундговь цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга Г.Мягмарсүрэн, Говьсүмбэр салбарын дарга Б.Баттуул, "Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн Өвөрхангай салбарын дарга Б.Дэмбэрэлсайхан, Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Адъяасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137003822

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

Төрийн өмчид бүртгэх, хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн "Дундговь цахилгаан түгээх сүлжээ салбар"-т бүртгэх хөрөнгийн жагсаалт							
1	Сайнцагаан сумын Цэнгэлдэх хүрээлэнгийн цахилгаан хангамж	2018			43,569,970.00	0	43,569,970.00
2	Сайнцагаан сумын шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж	2018			122,239,853.00	0	122,239,853.00
3	Луус сумын 0ь4 кВ цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл	2021			69,121,267.00	0	69,121,267.00
4	Дэд өртөөний барилга				118,628,052.00	0	118,628,052.00
5	0.4-6 кВ-ын гадна кабель шугам				299,603,602.00	0	299,603,602.00
6	10/04 кВ хүчдэлтэй 2*630 кВа чадалтай дэд өртөө 1 ком				162,988,941.00	0	162,988,941.00
7	10/04 кВ хүчдэлтэй 2*400 кВа чадалтай дэд өртөө 1 ком				144,411,472.00	0	144,411,472.00

Хэсгийн дүн						960,563,157.00	0	960,563,157.00
"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн Говьсүмбэр салбарт бүртгэх хөрөнгийн жагсаалт								
8	Говь-Угтаал сумын шинэ суурьшлын бүсэд 0.4 кВт цахилгаан шугамын өргөтгөл					64,996,453.00	0	64,996,453.00
Хэсгийн дүн						64,996,453.00	0	64,996,453.00
"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн Өвөрхангай салбарт бүртгэх хөрөнгийн жагсаалт								
9	Цахилгаан дэд станц шар эрэг /Дундговь аймаг Сайхан-Овоо сум/	2013	ш	1		22,200,000.00	18,685,000.00	3,515,000.00
10	Цахилгаан дэд станц Сэнжит хороолол /Дундговь аймаг Сайхан-Овоо сум/	2019	ш	1		20,400,000.00	2,108,000.00	18,292,000.00
11	Дэд станц Морин хөтөл /Дундговь аймаг Сайхан-Овоо сум/	2016	ш	1		29,000,000.00	10,472,222.00	18,527,778.00
12	0.4 кВ агаарын шугам /Дундговь аймаг Сайхан-Овоо сум/	1980	ш	78		5,460,000.00	0	5,460,000.00
13	0.22 кВ агаарын шугам /Дундговь аймаг Сайхан-Овоо сум/	1980	ш	119		8,330,000.00	0	8,330,000.00
Хэсгийн дүн						85,390,000.00	31,265,222.00	54,124,778.00
						1,110,949,610.00	31,265,222.00	1,079,684,388.00
НИЙТ ДҮН						(нэг тэрбум нэг зуун арван сая есөн зуун дөчин есөн мянга зургаан зуун арав)	(гучин нэгэн сая хоёр зуун жаран таван мянга хоёр зуун хорин хоёр)	(нэг тэрбум далан есөн сая зургаан зуун наян дөрвөн мянга гурван зуун наян найман)